

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС КОМПАНИ”
ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 дүгээр сарын 23 ны өдрийн
26/23 тоот тогтоолын Хавсралт 01



SOLOMON INVESTMENTS

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Баримт бичгийн төрөл/ Type:	Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
Хамрах хүрээ/ Area:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС КОМПАНИ” ХХК-ийн ажилтнуудад
Нууцын зэрэглэл/ Confidentiality:	Дотоодод нээлттэй
Баримт бичгийн дугаар/Number:	М/26/37
Боловсруулсан/ Prepared by:	Төлөөлөн удирдах зөвлөл
Баталсан/ Approved by:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС КОМПАНИ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хуудасны тоо/ Page number:	5 хуудас
Хянан нийцүүлэх давтамж:	Жилд 1 удаа
Батлагдсан огноо/ Effective date:	2026 оны 03 дүгээр сарын 23

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Соломон Инвестментс ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Компанийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хөтөлбөрийн оролцогч талууд нь Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), Гүйцэтгэх удирдлага, Компанийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид байна.
- 1.3. Хөтөлбөрийн оролцогч талууд хууль дээдлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэх, хамгаалах, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор хангах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 1.4. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 2.1 Хөтөлбөр нь дараах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Үүнд:
 - 2.1.1. Компани болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хооронд итгэлцэл болон оролцоог нэмэгдүүлэх, санал хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх;
 - 2.1.2. Компани хөрөнгө оруулагчдыг таньж мэдэх, цаашлаад учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор тухай бүр хуульд заасан шаардлагыг биелүүлж ажиллах;
 - 2.1.3. Техник, технологи, цахим суваг ашиглан түргэн шуурхай, ойлгомжтой, хялбар байдлаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчтэй харилцан мэдээлэл солилцох;
 - 2.1.4. Компанийн засаглалын тогтолцоог сайжруулах;
 - 2.1.5. Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх;
 - 2.1.6. Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад оршино.
- 2.2 Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан зорилтыг тавьж ажиллана. Үүнд:
 - 2.2.1. Компанийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийг ойлгомжтой, хялбар байдлаар холбогдох үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах;
 - 2.2.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлэх;
 - 2.2.3. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
 - 2.2.4. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийг тогтмол танилцуулж ажиллана.

- 2.3 Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэх боломжийг хангасан хэлбэрээр хүргэнэ.
- 2.3.1. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 - 2.3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 2.3.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;
 - 2.3.4. Зах зээлийн судалгаа;
 - 2.3.5. Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;
 - 2.3.6. Шаардлагатай бусад мэдээлэл.
- 2.4 Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.
- 2.4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр Компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах, санал бодлыг хүлээн авах;
 - 2.4.2. Боломжит хэлбэрээр (компанийн цахим хуудас, имэйл хаяг, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгууд гэх мэт) мэдээлэл хүргэх, солилцох;
 - 2.4.3. Шаардлагатай бусад.
- 2.5 Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
- 2.5.1 Мэдээлэл хүргүүлэх хөрөнгө оруулагч, нэгж эрх эзэмшигч, ТУЗ, болон бусад оролцогчдын жагсаалтыг гаргах;
 - 2.5.2 Мэдээлэл хүргүүлэх баримт бичгийн бүрдлийг хангах;

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ ХЭРЭГСЭЛ

- 3.1 Мэдээллийг холбогдох нэгж буюу нэгжийн хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба компанийн цахим хуудас, имэйл хаяг, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан ТУЗ, Компанийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1 Компанийн Гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.
- 4.2 Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд компанийн ТУЗ-өөс хяналт тавина.
- 4.3 Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор компанийн ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.